

**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ  
ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙНТӨЛӨВЛӨГӨӨНД  
ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ  
/2017 оны жилийн эцсийн байдлаар/**

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэт гэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	Яамны ажилтнуудад зориулсан үндсэн сургалт, сэдэвчилсэн лекц-ярилцлага, орчуулга, англи, монгол хэлний сургалтад хамруулах, байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах мэдээллээр хангах ажлыг холбогдох төлөвлөгөөний дагуу зохион байгуулав. Тухайлбал, “Дипломат ёслолын онол, арга зүй”, “Дипломат ажилтны хувцаслалт”, “Албан хэрэг хөтлөлт, архивын журам” “Дипломат баримт бичиг боловсруулах стандарт, аргачлал”, “ХАСУМ, ХАСХОМ бөглөх аргачлал”, “Үр дүнгийн гэрээ байгуулах аргачлал”, “Монгол Улсын түүх, гадаад харилцааны онцлог”, “Зөөлөн хүчний бодлого, түүгээр дамжуулан гадаад харилцааг үр өгөөжтэй хөгжүүлэх нь”, “Монгол Улсын гадаад харилцаа, нийгэм, эдийн засаг, гадаад худалдааны өнөөгийн төлөв байдал, ойрын үеийн зорилт, гадаад сурталчилгаа, соёлын харилцаа”, 11 газрын дэд захирлын мэдээллийн цаг зэрэг сэдэв бүхий 40 орчим цагийн 20 сургалтад яамны нийт ажилтнуудыг хамруулав. Мөн ДТГ-уудад ажиллахаар томилолт авсан ажилтнуудад зориулсан ерөнхий болон консулын дадлагажуулах сургалтуудыг Төрийн нарийн бичгийн даргын баталсан төлөвлөгөөний	Дотоод нөөц болоцоо, гаднаас авсан багш нарт 3,267,400.00 төгрөг.	

					дагуу холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулав. <b>Биелсэн 100%</b>		
		Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш		Сургалтуудын ирцийг тухай бүрд нь бүртгэж байсан. Зорилтод бүлгүүдийн оролцоог 80 хувиас дээш байсан. <b>Биелсэн 100%</b>		
		Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш		Гадаадын урт, богино хугацааны сургалтын талаарх мэдээллийг тухай бүр яам, ДТГ-ын нийт албан хаагчдад хүргүүлж, сонгон шалгаруулах замаар магистрийн сургалтад /нэг жил/ 3, дипломатын сургалтад /7-45 хоног/ 15, гадаад хэлний сургалтад /2-6 сар/ 5, нийт 23 ажилтан суралцуулсан бөгөөд 10 залуу ажилтныг 2018 оны 2 дугаар сард Шотланд Улсад синхрон орчуулгын эрчимжүүлсэн сургалтад хамруулахаар бэлтгэж байна. Түүнчлэн дотоодын байгууллагуудаас зохион байгуулсан мэргэшүүлэх болон давтан сургалт, семинарт яамны ажилтан, албан хаагчдыг түлхүү оролцуулахыг хичээж ажилласаны үр дүнд энэ онд нийтдээ давхардсан тоогоор 45 албан хаагчийг дотоодын сургалтад хамруулав. Мөн дипломат албаны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулах, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд зориулан салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн 2 боть бүхий “Дипломат албаны эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл”, дипломат ажлын технологи, үйл ажиллагааны зааварчилгаа бүхий “Дипломат ажилтны гарын авлага”, гадаад бодлогын тойм бүхий “Гадаад харилцааны яамны Хөх ном”-ыг тус тус хэвлүүлж, нийт ажилтнуудын ширээний ном болгов. <b>Биелсэн 100%</b>		
						Ном хэвлүүлэхэд 17,680,000.00 төгрөг,	
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн	70 хувиас дээш		Яам, ДТГ-ын ажилтнуудын 96% нь 3-аас дээш жил төрийн албанд ажилласан. <b>Биелсэн 100%</b>		

			боловсон хүчний үзүүлэлт				
		Хэсгийн дундаж:					
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	Яам, ДТГ-ын 4 ажилтанд дипломат дээд цол олгуулсан /“Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд” цолыг -3, “Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” цолыг - 1/. Мөн 6 ажилтныг төрийн одон медалиар шагнуулсан “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” -2,“Алтан гадас” одон- 1, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар-3/. Түүнчлэн 10 ажилтанг мөнгөн шагналаар урамшуулсан болно. <b>Биелсэн 100%</b>		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	Нийтдээ яам, ДТГ-ын 23 ажилтны дипломат цол, төрийн захиргааны зэрэг дэвийг ахиулж /“Тэргүүн шадар” цолоор- 4, “Шадар” цолоор – 1, “Тэргүүн итгэмжит” цолоор-10, “Итгэмжит” цолоор-7,“Тэргүүн зэргийн ахлах түшмэл”–2,“Дэд зэргийн ахлах түшмэл”-1/, 10 ажилтаны албан тушаал /Нэгдүгээр нарийн бичгийн даргаар- 1, Хоёрдугаар нарийн бичгийн даргаар- 6, Гуравдугаар нарийн бичгийн даргаар/ дэвшүүлэв. <b>Биелсэн 100%</b>	Шагнах тухай шийдвэр 2017 оны 12 дугаар сарын сүүлээр гарсан.	
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Албан ёсны санал асуулга явагдаагүй. Гэхдээ ажилтан, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор яамны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилгыг дуусган, ашиглалтад оруулж, 9 газрыг нүүлгэн шилжүүлж, өрөө тасалгаануудыг тавилгажуулах, хурлын болон уулзалтын танхимууд, цайны болон визитийн үйлчилгээний өрөөнүүд, бялдаржуулах танхимыг бүрэн тохижуулсан нь албан хаагчдаас эерэг үнэлгээ авсан болно. <b>Биелсэн 100%</b>	Хөрөнгө оруулалт 1.8 тэрбум төгрөг.	
			Албан хаагчдад сар	Гүйцэтгэлээр	Төсвийн нөхцөл байдлаас шалтгаалан 2017 онд ажилтнуудад олгодог өдрийн хоол, унааны мөнгө	1,267,200.00 төгрөг.	

		бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх		нэмэгдээгүй /1 өдрийн: хоол –4000₮, унаа- 800₮/. <b>Үнэлэх боломжгүй</b>		
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлыг шат дараатайгаар шийдвэрлэх ажлын хүрээнд төлбөрийг нь яамнаас хариуцаж 2017 оны 09 дүгээр сарын 27-ноос 12 дугаар сарын 6-ны хооронд “Интермэд” эмнэлэгт 140 албан хаагчийг, гэр бүлийн гишүүдийг нь хөнгөлөлттэй тарифаар эрүүл мэндийн багц шинжилгээнд хамруулав. Мөн яамны төв аппаратын ажилтнууд болон ахмад дипломатуудыг ХЗДХЯ-ны харьяа Төрийн тусгай албаны албан хаагчдын эмнэлгийн үйлчилгээнд хамруулахаар болсон. <b>Биелсэн 100%</b>	32,890,000.00 төгрөг.	
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	<b>98.5 хувь</b>		
Хэсгийн дундаж:						
Үнэлгээний дундаж хувь: <b>89.8%</b>						